



СҮХБААТАР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 57

Баруун-Урт

Дэд хөтөлбөр, төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 25 дугаар зүйлийн 25.4, "Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2010 оны 90 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж буй "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2 дугаар шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэх "Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр"-ийг нэгдүгээр, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх, төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /З.Энхтөр /-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Н. Азжаяа/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2012 оны 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.МӨНХБАТ



D:/My Documents /A-4 doc

0100 114

**СҮХБААТАР АЙМГИЙН “ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ  
ДЭД ХӨТӨЛБӨР”/2017-2020 ОН/**

**Нэг. Хөтөлбөрийн зорилго:**

Аймгийн “Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр”-ийн зорилго нь цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх замаар байгаль орчны тэнцвэрт байдлыг хангахад оршино.

**Хоёр. Аймгийн цөлжилтийн төлөв байдал**

2.1. Манай аймгийн газар нутаг цөлжилт газрын доройтолд өртөх эрсдэл өндөртэй нутагт хамрагддаг ба дараах хүчин зүйлийн нөлөөгөөр цөлжилт үүсэж байна. Үүнд:

- ✓ Газар нутаг жигд талархаг байдалтай, нөмөр нөөлөг багатай.
- ✓ Хөрсний үржил шим бага, гол төлөв элсэнцэр хөрстэй
- ✓ Газар зүйн байрлалын хувьдалсын салхи нэгдэн хүч авах талбар нь болж байдаг.

Сүхбаатар аймаг нутаг дэвсгэр дэх агаарын температурын өөрчлөлтийн судалгааны дүнгээс үзэхэд 47 жилийн дотор жилийн дундаж температур аймгийн нутгаар 1,88-2,26<sup>0</sup> С-аар дулаарсан. Дулааралт явагдаж байгаагаас тогтвортой цасан бүрхүүлтэй байх хоногийн тоо 30 жилийн дотор бараг бүтэн 1 сараар богиносж, хөрс нүцгэн байдаг хугацаа уртасчээ. Сүүлийн жилүүдийн нийлбэр хур тунадас жил тутам 5-7мм-ийн хурдтай буурч байгаа нь цөлжилт газрын доройтолд өртөхөд ихээхэн нөлөө үзүүлж байна.

Говь цөлийн нөлөө Наран, Онгон, Баяндэлгэр, Түвшинширээ сумдын нутагт туссан, тэр хэсгээрээ цөлөрхөг байдалтай болсонтой холбоотой ба өөрөөр хэлбэл аймгийн нутаг дэвсгэр бүхэлдээ байгалийн нөхцөлөөр цөлжилтөнд өртөх магадлал өндөртэй тул хүний хүчин зүйлийн зохисгүй үйл ажиллагааг хязгаарлах, хур тунадас хомс гантай үе удаан үргэлжлэх тохиолдолд малын бэлчээрт хүндрэл учирч эцэстээ газрын доройтолд хүрч байна.

2008 онд ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгээс хийсэн цөлжилтийн судалгаагаар цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд багтах нутаг эрс нэмэгдсэн байна.

- ✓ Цөлжилтийн төлөв байдлыг үнэлэхэд:
- ✓ Цөлжилт илрээгүй-4,1%
- ✓ Сул илэрсэн-4,11%
- ✓ Дунд зэрэг-59%
- ✓ Хүчтэй -31,18%
- ✓ Нэн хүчтэй -1,7%-ийн дүн гарсан байна.

Цөлжилт газрын доройтол ихэнхдээ байгалийн хүчин зүйл, хүний буруутай үйл ажиллагааны улмаас үүсэж байна. Судалгаанаас үзэхэд аймгийн хэмжээнд ургамлын

индекс 0,12-0,51 хооронд хэлбэлздэг ба Эрдэнэцагаан, Мөнххаан, Түмэнцогт сумдад 0,40-өөс их, Түвшинширээ, Баяндэлгэр, Онгон, Наран, Уулбаян сумдад 0,3-аас бага байна. Өөрөөр хэлбэл ургамлын ургалт нутгийн баруун өмнөд хэсгээр муу, харин баруун хойд болон зүүн өмнөд хэсгээр сайн байна.

Өнөөгийн байдлаар аймгийн нутагт хээр говийн бүсийн цэгэн цөлжилтийн тойргууд ихээр ажиглагдах болж байна. Тухайлбал аймаг, сум, суурин газруудын төв, ашиглагдаж буй уул уурхайн орд газрууд, цэргийн анги, голын татам, нуур булаг шанд зарим Баянбүрд, худаг уст цэг, өвөлжөө хаваржаа, тариалангийн талбай зэрэг болно.Эдгээрээс сум суурин газруудын орчин нь тодорхой радиусаар их, бага зэрэглэлээр талхагдалд орсон ялангуяа Асгат, Онгон, Түвшинширээ, Баяндэлгэр, Дарьганга сумдын төв мөн аймгийн төвийн эргэн тойронд 1,2-1,5 км өргөн зурваст талхагдалд орж цөлжилтийн хүчтэй зэрэглэлд багтах хэмжээнд хүрсэн.

Газрыг зохисгүй ашигласантай холбоотой элсний нүүлт хөдөлгөөн сүүлийн 10 гаруй жилд идэвхитэй явагдаж сумын төв хөдөөд хөдөлгөөнт сул элсний хэмжээ жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна.

Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенцийн жагсаалтанд орсон тус аймгийн Дарьганга сумын нутагт орших Ганга нуур нь уур амьсгалын өөрчлөлт,хүний үйл ажиллагааны нөлөөллийн улмаас нуурын усан толиот хэсгийн 60 хувь нь татарч,хөвөөний хэсгээс 200-300 м дотогшилж ширгэх аюул нүүрлээд байна.

### **Цөлжилттэй тэмцэх талаар хийсэн бодит ажилуудаас:**

- Дарьганга сум-Молцог элс,Түмэнцогт сум-Хар ямаат,Эрдэнэцагаан сум-Хөндлөн хайлааст зэрэг байгалийн дурсгалт болон нөөц газруудад байгалийн аясаар ургаж буй ойн төгөлд судалгаа хийлгэх саналыг ойн газарт санал тавьж судалгаа хийлгэсэн.Судалгаагаар 15,6 мян.га талбай бүхий ойн сан байгааг тогтоож МУ-ын ойн сангийн бүртгэлд бүртгүүлсэн. Ойн санд бүртгүүлснээр Засгийн газрын 2012 оны 255 дугаар тогтоолоор тус аймагт Сум дундын ойн анги байгуулах шийдвэр гарсан.
- БОАЖГ-ын дэргэд 1 га-д Мод үржүүлгийн талбайг байгуулж нутгийн мод сөөгийг тарьж ургуулах ажлыг эхлүүлсэн. Өмнөговь аймгаас говь хээрийн ганд тэсвэртэй сухай,жигд зэрэг мод сөөгийг үрээр болон мөчрөөр тарималжуулсан.
- Засгийн газрын 255,аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 35 дугаар тогтоолоор "Сүхбаатар-Ойжуулалтсум дундын ойн анги" ОНӨҮГ-ыг байгуулсан.
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх "Шарга бороо-1,2 гэсэн 2 экспедиц ажиллаж байна. 2012-2016 онд нийт 114 удаа Цаг агаарт зориудаар нөлөөлж 11 суманд 180 гаруй пуужин харвасан байна.Олон жилийн дундаж нь 120-210 мм тунадас оруулсан.Олон жилийн дунджаас 10-30 %-иар нэмэгдүүлсэн. Мөнгөн дүнгээр илэрхийлбэл 295.462.640 төгрөгийн үнэ бүхий 285.410м<sup>3</sup> хур усыг оруулсан байна.
- Бэлчээрийн даац багтаамж 2012-2017 оны судалгаагаар Баяндэлгэр, Уулбаян,Түвшинширээ,Онгон,Дарьганга,Асгат сумдын нутгаар, Баруун-Урт,Халзан,Эрдэнэцагаан,Түмэнцогт,Мөнххаан сумдын төвийн багуудаар олон дахин хэтэрсэн судалгаа гарсан.

- Бэлчээрийн мэрэгч амьтантай тэмцэх ажлыг 165.0 мян/га-д гүйцэтгэж нийт 261.8 сая төгрөгийн зардлыг улс болон орон нутгийн төсвөөс зарцуулсан. Давхардсан тоогоор 27 суманд хийсэн.
- 2012-2016 онд аймгийн нутаг дэвсгэр дээр байнгын урсгалтай 278 булаг шанд тоологдсон бөгөөд байгаль орчин,нийгэм эдийн засагт онцгой ач холбогдолтойгоор ангилан үзээд 56 булаг шандны эхийг улс,орон нутгийн төсөв,гадаадын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар тохижуулан хашиж хамгаалсан.
- Аймгийн нутаг дэвсгэр 8.228.715 га газар хамрагддаг бөгөөд улсын тусгай хамгаалалтанд 7,2%, аймаг орон нутгийн хамгаалалтанд 23% буюу нийт нутгийн 30% нь улс,орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаж байна.
- Экологийн ач холбогдолтой болон элэгдэл доройтолд орж буй газруудад ойн зурвас байгуулах,төв суурингийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг улс болон орон нутгийн төсвөөр гүйцэтгэж байна. Ойн зурвас байгуулах ажлыг 2012-2016 онд 40 га-д 62.0 сая төгрөгөөр Баруун-Урт,Дарьганга,Онгон,Түмэнцогт сумдын нутагт гүйцэтгэсэн.
- Ганга нуурын экосистемийн судалгааг 2012 онд “Экологи судалгааны төв”-өөр 60 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн. Судалгаанаас гарсан зөвлөмжийн дагуу мод тарьж элсний нүүлтийг багасгах мод сөөг тарих, хашаа хамгаалалтыг сайжруулах ажил хийсэн.
- Аймгийн хэмжээний төв суурин газрын хөрс,агаарын бохирдлыг бууруулах ногоон байгууламжийг нэмэгдүүлхээр 2012-2016 онд нийт 84.590 ш мод,сөөг тарьж ургуулах ажлыг зохион байгуулж ногоон байгууламжийн талбай 165.2 га-гаар нэмэгдсэн.Цэцэрлэгт хүрээлэн болон бичил цэцэрлэг 9-өөр нэмэгдсэн.
- Ойжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж байгаа төр болон ТББ,иргэн 6 ажиллаж мод үржүүлгийн талбай 10 га талбайд мод сөөгийг их бага хэмжээгээр тарьж байна. ТББ-иудыг материаллаг баазыг сайжруулан,чадвахижуулж төв суурингийн цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлж байна. “Сүхбаатар-Ойжуулалт сум дундын ойн анги” ОНӨҮГ, Ойжуулалт-Хайлааст ХХК, Шаргын модот цэцэрлэг ХХК-иудыг усны машинтай болгож төвийн цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх ажлуудыг хийж байна.

**Гурав. Дэд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа  
Тэргүүлэх чиглэл 1: Чадавхийг бэхжүүлэх;**

- 1.1. Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны үндсэн чиглэлд цөлжилттэй тэмцэх ажлыг тусган хэрэгжилтийг хангуулж, жил бүр төлөвлөн зохион байгуулах.
- 1.2. Аймаг,сум,багийн Засаг даргын үр дүнгийн гэрээнд цөлжилттэй тэмцэх ажлыг тусган дүгнэдэг болох.
- 1.3.Цөлжилттэй тэмцэх орон нутгийн чадвахийг бэхжүүлэх зорилгоор байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарыг сургаж,мэргэшүүлэх.
- 1.4.Аймгийн “Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвлөлийг аймаг,сумдад байгуулж ажиллах.
- 1.5. Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнүүдэд цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.

- 1.6. Аймаг, сумын цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ИТХТ-ээр батлуулж хэрэгжилтийг тайлагнах.
- 1.7. Бүс нутгийн экологийн нөхцөлд тохирсон, байгалийн нөөц ашиглалтын харилцааг зохицуулах орон нутгийн эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлаж ажиллах.
- 1.8. Цөлжилттэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, нөхөрлөл, бүлэг, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих.
- 1.9. Мод үржүүлэг, ойжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-иудыг хөрш зэргэлдээ ӨМӨЗО-ны мод тарьж элсний нүүлтийг сааруулах туршлагыг судлах.
- 1.10. Аймаг, сумд бэлчээрийн менежментийн нэгдсэн төлөвлөгөөтэй болох.

## **2. Тэргүүлэх чиглэл: Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;**

- 2.1. Сумдын газар ашиглалтын болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд цөлжилт, газрын доройтлын эсрэг авч явуулах арга хэмжээг жил бүр тусган биелэлтэнд нь хяналт тавьж ажиллах.
- 2.2. Цөлжилттэй холбоотой төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан эрх зүйн актыг мөрдөж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах.
- 2.3. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээг тусган хөрөнгө санхүүгийн дэмжлэг авах.
- 2.4. Цөлжилтийг бууруулахад мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг шинэчлэн хэрэгжүүлж ажиллах.
- 2.5. Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх заавар, журмыг шинэчлэн боловсруулах, нөхөн сэргээх арга зүйг боловсронгуй болгох.
- 2.6. Бэлчээр ашиглагчдын болон хадлан бэлтгэгчдын эрх үүргийг тодорхой болгох хадлан бэлтгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- 2.7. Газрын төлөв байдал, чанарыг хянах үйл ажиллагааг газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ дүгнэх, үйл ажиллагаатай уялдуулан газарт учруулсан хохирлыг тооцох, барагдуулах, хариуцлага тооцох замаар цөлжилт газрын доройтолыг бууруулах механизмыг бүрдүүлэх.

## **Тэргүүлэх чиглэл: 3. Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх;**

- 3.1. Аймгийн хэмжээний цөлжилтийн судалгааг ШУ-ны байгууллагаар хийлгэх, мэдээлэлийн цахим санг бий болгох.
- 3.2. Аймгийн цөлжилтийн зураглалтай болох.
- 3.3. Газрын хөрс, ургамлан бүрхэвчийн доройтол, цөлжилтийн үйл явцыг судлах, суурин судалгаа хийх.
- 3.4. Цөлжилт, газрын доройтолын төлөв байдал тэдгээрийн үр дагаврын талаархи мэдлэг мэдээллийг олон нийтэд болон шийдвэр гаргагчдад хүргэх.
- 3.5. Говь цөлийн бүсийн баян бүрдэг хамгаалах, зориудаар нөхөн сэргээх зорилгоор Мод үржүүлгийн газруудыг шинжлэх ухааны үндэслэлтэй барьж байгуулах, одоо байгаа аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, чадвахижуулах.

## **4. Тэргүүлэх чиглэл: Сурталчилгаа оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих**



- 4.1. Байгаль хамгаалах уламжлалт зан үйл, ёс заншил, арга замын талаар сургалт сурталчилгааны ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх.
- 4.2. Байгальд ээлтэй Эко сургуулиудын тоог нэмэгдүүлэх, дэмжих.
- 4.3. Аймгийн БОАЖГ-ын харъяа сургалт сурталчилгааны төв байгуулах.
- 4.4. НҮБ-ын цөлжилттэй тэмцэх Конвенцийн газраас гаргасан шийдврийн дагуу Олон улсын цөлжилттэй тэмцэх өдрийг иргэд олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.
- 4.5. Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулахад идвэхи санаачилгатай ажиллаж байгаа иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг урамшуулан дэмжих тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах.
- 4.6. Цөлжилт хүчтэй илэрсэн сумдыг сонгож, цөлжилттэй тэмцэх загвар сум бий болгоход олон улсын байгууллагуудын анхаарлыг хандуулах.
- 4.7. Бэлчээр ашиглагчдын эрх үүргийг тодорхой болгох талаар судлах, бэлчээр ашиглагчдыг мэдээллээр хангах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах.

**Тэргүүлэх чиглэл 5. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;**

- 5.1. Аймгийн хэмжээний төв суурин газруудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 5.2. Ногоон хэрэм, ойжуулалтын ажлыг хангах зорилгоор Дарьганга, Уулбаян, Түмэнцогт сумдад стандартын мод үржүүлгийн газар байгуулж ажиллана.
- 5.3. Жил бүр Ойн зурвас байгуулах ажлыг 10-20 га-д хийж гүйцэтгэх.
- 5.4. Усны ундаргыг хамгаалах, ашиглалтгүй байгаа хуучин худгийг сэргээн засварлах шинээр худаг, уст цэг гаргах замаар гандуу бүс нутгийн усан хангамжийг сайжруулах. Жилд 10-15 худаг гаргах ажлыг зохион байгуулна.
- 5.5. Жил бүр аймгийн хэмжээнд 3-5 булгийн эхийг хашиж, хамгаалж усан хангамжийг нэмэгдүүлэх.
- 5.6. Булаг шанд хамгаалах, тохижуулах талаар бодит үйл ажиллагаа явуулж буй иргэд, малчдын бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
- 5.7. Асгат, Баруун-Урт, Мөнххаан, Эрдэнэцагаан сумдад "Ногоон хэрэм" хөтөлбөрийн ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах, үр дүнг сайжруулах.
- 5.8. Ашигт малтмалын хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, олборлолт явуулсан газрын нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэх.
- 5.9. Бэлчээр сэлгээх, өнжөөх ажлыг төлөвлөх, хадлан тэжээлийн бүс нутгийг тогтоох.
- 5.10. Сумдад байгаль хамгаалах нөхөрлөлийг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх.
- 5.11. Говь хээрийн болон цөлжилт ихээр явагдаж байгаа бүсэд ус хуримтлуулах, хиймэл нуур, хөв, цөөрөм байгуулах замаар экосистемийн тэнцвэрт байдал Дарьганга, Түмэнцогт сумдын Байгалийн дурсгалт болон байгалийн нөөц газрын баян бүрдийг хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг дэмжих.
- 5.12. Дарьганга, Түмэнцогт сумдын Байгалийн дурсгалт болон байгалийн нөөц газрын баян бүрдийг хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

5.13.Бэлчээр хамгаалах зохистой ашиглах,таримал бэлчээр бий болгох, хортон мэрэгчтэй тэмцэх,нөхөн сэргээхэд санаачилга гарган ажиллаж буй бэлчээр ашиглагч,малчдын бүлгийн ажилд дэмжлэг үзүүлэх.

5.14.Бүс нутгийн онцлог,бэлчээрийн даац багтаамжид тохируулан сүргийн оновчтой бүтцийг бий болгох арга хэмжээ авах.

5.15. Малчдын оролцоотойгоор бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.

5.16.Тариалангийн талбайн хөрсийг элэгдлээс хамгаалж хөрсний чанарыг бууруулахгүй байх зорилгоор ээлжлэн тариалалтыг зөв сэлгээтэй ашиглаж ойн зурвас байгуулж хөрсийг хамгаалах.

#### **Дөрөв. Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:**

4.1. Хөтөлбөр хэрэгжих хугацаа 2017-2020 онуудад.

#### **Тав. Дэд хөтөлбөрийн удирдлага,санхүүжилт:**

5.1. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах,зохицуулах ажлыг Засаг даргын удирдлага доор аймгийн Цөлжилттэй тэмцэх зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.

5.2.Суманд сумын Засаг дарга зохион байгуулна.

5.3.Хөтөлбөрийн хэрэгжилт,ажлын тайлан,төсвийг жил бүрийн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн тодотгож батлуулна.

#### **Зургаа. Дэд хөтөлбөрийн санхүүжилт:**

А. Улсын болон орон нутгийн төсвөөс;

Б.Холбогдох хууль тогтоомжоор орон нутгийн төсөвт төвлөрөх хөрөнгөөс;

В.Олон улсын байгууллага,гадаад,дотоодын төсөл,ААНБ,иргэдийн хандив,тусламж;

----- оОо -----

**СҮХБААТАР АЙМГИЙН “ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙГ  
 ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ II ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2020 ОН)**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	хугацаа	Гарах үр дүн	Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр	Хамтран хариуцан ажиллах байгууллага
<b>Тэргүүлэх чиглэл 1: Чадавхийг бэхжүүлэх</b>					
1.1	Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны үндсэн чиглэлд цөлжилттэй тэмцэх ажлыг тусган хэрэгжилтийг хангуулж, жил бүр төлөвлөн зохион байгуулах.	2017-2020	ШУ-д суурилсан хөгжлийн ерөнхий чиг хандлагыг тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийн үе шат тодорхойлогдоно.	Орон нутгийн төсөв	Аймгийн ИТХ, ЗДТГ
1.2.	Аймаг, сум, багийн Засаг даргын үр дүнгийн гэрээнд цөлжилттэй тэмцэх ажлыг тусган дүгнэдэг болох.	2017-2020	Аймаг, сум, багийн хэмжээнд цөлжилт, газрын доройтолтой тэмцэх ажил сайжирна.	Орон нутгийн төсөв	Бүх шатны Засаг дарга
1.3.	Цөлжилттэй тэмцэх орон нутгийн чадвахийг бэхжүүлэх зорилгоор байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарыг сургаж, мэргэшүүлэх.	2017-2018	Цөлжилт, газрын доройтолыг бууруулах арга хэмжээг төлөвлөх, урьдчилан мэдээлэх нөхцөл бүрдэнэ.	Улс, орон нутгийн төсөв	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ
1.4.	Аймгийн “Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвлөлийг аймаг, сумдад байгуулж ажиллах.	2017	Тухайн сум, орон нутгийнхаа байгалийн онцлогт тохирсон оновчтой шийдвэр гаргаж ажиллана.	Орон нутгийн байгаль хамгаалах сан	Аймаг, сумын ЗДТГ
1.5.	Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнүүдэд цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.	2017-2020	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжинэ.	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ БОАЖГ
1.6.	Аймаг, сумын цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ИТХТ-ээр батлуулж хэрэгжилтийг	2017-2020	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулснаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Орон нутгийн төсөв	Бүх шатны Засаг дарга



	тайлагнах.		тодорхой болно.		
1.7.	Бүс нутгийн экологийн нөхцөлд тохирсон, байгалийн нөөц ашиглалтын харилцааг зохицуулах орон нутгийн эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлаж ажиллах.	2017-2020	Орон нутгийн өөрөө өөрийгөө удирдах хууль эрх зүйн уян хатан тогтолцоо бүрдэнэ.	Хөрөнгө шаардлаггүй	Аймаг, сумдын ИТХ, ЗДТГ
1.8.	Цөлжилттэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, нөхөрлөл, бүлэг, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих.	2017-2020	Цөлжилт, газрын доройтолыг бууруулахад олон нийтийн оролцоо нэмэгдэнэ.	Орон нутгийн төсөв	Аймаг, сумын ЗДТГ, БОАЖГ
1.9.	Мод үржүүлэг, ойжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-иудыг хөрш зэргэлдээ ӨМӨЗО-ны мод тарьж элсний нүүлтийг сааруулах туршлагыг судлах.	2017-2020	Хөрш зэргэлдээ орны туршлагыг нэвтрүүлж ажиллана.	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ БОАЖГ
1.10	Аймаг, сумд бэлчээрийн менежментийн нэгдсэн төлөвлөгөөтэй болох.	2017-2020	13 сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй болсон байна.	Төсөл хөтөлбөр	Аймгийн ЗДТГ ХХААГ
<b>2.Тэргүүлэх чиглэл: Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох</b>					
2.1.	Сумдын газар ашиглалтын болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд цөлжилт, газрын доройтлын эсрэг авч явуулах арга хэмжээг жил бүр тусган биелэлтэнд нь хяналт тавьж ажиллах.	2017-2020	Цөлжилт, газрын доройтолыг бууруулах бүсчилсэн төлөвлөгөө боловсруулагдана.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ГХБХБГ БОАЖГ ХХААГ
2.2.	Цөлжилттэй холбоотой төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан эрх зүйн актыг мөрдөж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах.	2017-2020	Үүрэг хариуцлагын тогтолцоо бүрдэнэ.	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ БОАЖГ, ШУХүрээлэн шинжээчид
2.3.	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээг тусган хөрөнгө санхүүгийн дэмжлэг авах.	2017-2020	Санал, санаачилгыг санхүүжүүлэх хөхүүлэн дэмжих сайн засаглалын орчин бүрдэнэ.	Улс, орон нутгийн төсөв	БОАЖЯ Аймгийн ЗДТГ
2.4.	Цөлжилтийг бууруулахад мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг	2017-2020	Цөлжилт, газрын доройтолоос хамгаалж мод тарьж ургуулах иргэд, олон	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ БОАЖГ

	шинэчлэн хэрэгжүүлж ажиллах.		нийтийн оролцоо нэмэгдэнэ.		
2.5.	Хүчтэй элэгдэл,эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх заавар,журмыг шинэчлэн боловсруулах,нөхөн сэргээх арга зүйг боловсронгуй болгох.	2017-2020	Нөхөн сэргээх арга зүй сайжирна.	Шаардлагагүй	БОАЖЯ БОАЖГ
2.6.	Бэлчээр ашиглагчдын болон хадлан бэлтгэгчдын эрх үүргийг тодорхой болгох хадлан бэлтгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.	2017-2020	Бэлчээрийг зохистой ашиглах зохицуулалт бий болно.	Шаардлагагүй	Бүх шатны засаг дарга
2.7.	Газрын төлөв байдал,чанарыг хянах үйл ажиллагааг газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ дүгнэх, үйл ажиллагаатай уялдуулан газарт учруулсан хохирлыг тооцох, барагдууах, хариуцлага тооцох замаар цөлжилт газрын доройтолыг бууруулах механизмыг бүрдүүлэх.	2017-2020	Газрын доройтол цөлжилт багасна.	Улс,орон нутгийн төсөв	Аймаг, сумын Засаг ГХБХБГ
<b>Тэргүүлэх чиглэл: 3.Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх</b>					
3.1.	Аймгийн хэмжээний цөлжилтийн судалгааг ШУ-ны байгууллагаар хийлгэх, мэдээлэлийн цахим санг бий болгох.	2018	Аймгийн хэмжээний цөлжилтийн судалгааг иж бүрнээр хийлгэснээр цөлжилт, газрын доройтолтой тэмцэх арга аргачлалтай болж цөлжилтөнд өртөх газар нутгийн хэмжээ багасна.	Улс,орон нутгийн төсвөөр	Аймгийн ЗДТГ ШУБ БОАЖГ
3.2.	Аймгийн цөлжилтийн зураглалтай болох.	2017-2020	Цөлжилтийн зурагтай болсон байна.	Орон нутгийн төсөв	БОАЖЯ БОАЖГ
3.3.	Газрын хөрс, ургамлан бүрхэвчийн доройтол, цөлжилтийн үйл явцыг судлах, суурин судалгаа хийх.	2017-2020	Цөлжилтийн мэдээллийн судалгаагаар болсон байна.	Улсын төсөв,төсөл хөтөлбөр	Аймаг, сумдын ЗДТГ Аймгийн УЦУОШГ
3.4.	Цөлжилт, газрын доройтолын төлөв байдал тэдгээрийн үр дагаврын талаархи мэдлэг мэдээллийг олон нийтэд болон шийдвэр гаргагчдад хүргэх.	2017-2020	Мэдээлэл боловсронгуй болж шийдвэр гаргагчдад хүрсэн байна.	Улсын төсөв	Аймгийн ЗДТГ БОАЖГ БСГ
3.5.	Говь целийн бүсийн баян бүрдыг хамгаалах, зориудаар нөхөн сэргээх зорилгоор Мод үржүүлгийн газруудыг	2017-2020	Мод үржүүлгийн газрууд байгуулагдсан байх ба одоо ажиллаж байгаа газрууд	Улс орон нутгийн	Аймаг, сумын ЗДТГ БОАЖГ

	шинжлэх ухааны үндэслэлтэй барьж байгуулах, одоо байгаа аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, чадвахижуулах.		чадвахжсан байна.	төсөв, төсөл хөтөлбөр	
<b>4.Тэргүүлэх чиглэл: Сурталчилгаа оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих</b>					
4.1.	Байгаль хамгаалах уламжлалт зан үйл, ёс заншил, арга замын талаар сургалт сурталчилгааны ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх.	2017-2020	Суртгалт сурталчилгааны ажил хийгдэнэ.	Төсөл хөтөлбөр улс, ОНТ	БОАЖЯ БОАЖГ
4.2.	Байгальд ээлтэй Эко сургуулиудын тоог нэмэгдүүлэх, дэмжих.	2017-2020	Эко сургуулиудын тоо нэмэгдэж сурагчдын байгаль орчноо хамгаалах мэдлэг нэмэгдэнэ.	Төсөл хөтөлбөр улс, ОНТ	БОАЖГ БСУГ
4.3.	Аймгийн БОАЖГ-ын харъяа сургалт сурталчилгааны төв байгуулах.	2017-2020	Ганга нуурын дэргэд байгуулна. Сургалт сурталчилгааны төв байгуулагдснаар мэдээлэл түгээх ажил сайжирна.	Төсөл хөтөлбөр улс, ОНТ	Аймгийн ЗДТГ БОАЖГ ДБЦГХ Захиргаа
4.4.	НҮБ-ын цөлжилттэй тэмцэх Конвенцийн газраас гаргасан шийдврийн дагуу Олон улсын цөлжилттэй тэмцэх өдрийг иргэд олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.	2017-2020	Цөлжилттэй тэмцэх олон улсын өдрийг тэмдэглэж хэвшсэн байна.	Төсөл хөтөлбөр улс	БОАЖГ ХХААГ ГХБХБГ УЦУОШГ
4.5.	Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулахад идвэхи санаачилгатай ажиллаж байгаа иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг урамшуулан дэмжих тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах.	2017-2020	Иргэд нөхөрлөл, аж ахуйн нэгж, ТББ-иудын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	Төсөл хөтөлбөр улс, орон нутгийн төсөв	Аймаг, сумын ЗДТГ БОАЖГ
4.6.	Цөлжилт хүчтэй илэрсэн сумдыг сонгож, цөлжилттэй тэмцэх загвар сум бий болгоход олон улсын байгууллагуудын анхаарлыг хандуулах.	2017-2020	1-ээс доошгүй төсөл хэрэгжсэн байна.	Төсөл хөтөлбөр, улсын төсөв	Аймаг, сумдын ЗДТГ ХХААГ
4.7.	Бэлчээр ашиглагчдын эрх үүргийг тодорхой болгох талаар судлах, бэлчээр ашиглагчдыг мэдээллээр хангах, бэлчээрийн менежментийн	2017-2020	Арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулсан байна.	Улс орон нутгийн төсөв	Бүх сумдын Засаг дарга ХХААГ

	төлөвлөгөө боловсруулах.				
<b>Тэргүүлэх чиглэл 5. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</b>					
5.1.	Аймгийн хэмжээний төв суурин газруудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	2017-2020	13 сумын төв ногоон байгууламжтай болно.	Орон нутгийн төсөв	Аймаг, сумын ЗДТГ БОАЖГ
5.2.	Ногоон хэрэм, ойжуулалтын ажлыг хангах зорилгоор Дарьганга, Уулбаян, Түмэнцогт сумдад стандартын мод үржүүлгийн газар байгуулж ажиллана.	2017-2020	Дарьганга, Түмэнцогт, Уулбаян сумдад мод үржүүлгийн газар шинээр байгуулагдана.	Төсөл, хөтөлбөр ОНТ	Сумдын ЗДТГ БОАЖГ
5.3.	Жил бүр Ойн зурвас байгуулах ажлыг 10-20 га-д хийж гүйцэтгэх.	2017-2020	Ойн зурвас байгуулснаар цөлжилт газрын доройтолоос хамгаална.	Улс, орон нутгийн төсөв	Аймаг, сумын ЗДТГ БОАЖГ
5.4.	Усны ундаргыг хамгаалах, ашиглалтгүй байгаа хуучин худгийг сэргээн засварлах шинээр худаг, уст цэг гаргах замаар гандуу бүс нутгийн усан хангамжийг сайжруулах. Жилд 10-15 худаг гаргах ажлыг зохион байгуулна.	2017-2020	Гангийн нөлөөг бууруулж байгалиас хараат байдлыг багасгаж, мал аж ахуй газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах эхлэл тавигдана.	Улс, орон нутгийн төсөв	БОАЖГ ХХААГ "Сүхбаатар-ойжуулалт" ойн анги
5.5.	Жил бүр аймгийн хэмжээнд 3-5 булгийн эхийг хашиж, хамгаалж усан хангамжийг нэмэгдүүлэх.	2017-2020	Ус булгийн эхийг хамгаалснаар усны ундарга сайжирч, бэлчээрийн талхагдал багасна.	Улс, орон нутгийн төсөв	БОАЖГ Сумдын ЗДТГ, Сав газрын захиргаад
5.6.	Булаг шанд хамгаалах, тохижуулах талаар бодит үйл ажиллагаа явуулж буй иргэд, малчдын бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	2017-2020	Булаг шандны эхийг хамгаалах ажилд иргэдийн оролцоо нэмэгдэнэ.	ОНТ, хувийн хөрөнгөөр	БОАЖГ ХХААГ
5.7.	Асгат, Баруун-Урт, Мөнххаан, Эрдэнэцагаан сумдад "Ногоон хэрэм" хөтөлбөрийн ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах, үр дүнг сайжруулах.	2017-2020	Ойн зурвас байгуулснаар хөрс хамгаалагдана.	Улсын төсвөөр	БОАЖЯ БОАЖГ
5.8.	Ашигт малтмалын хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, олборлолт явуулсан газрын нөхөн сэргээлтийг	2017-2020	Байгальд халгүй, хариуцлагатай уул уурхайн тогтолцоо бүрдэнэ.	ОНТ Уул уурхайн компаний зардал	Аймаг, сумдын ИТХ, ЗДТГ МХГ БОАЖГ

	бүрэн хийлгэх.				
5.9.	Бэлчээр сэлгээх, өнжөөх ажлыг төлөвлөх, хадлан тэжээлийн бүс нутгийг тогтоох.	2017-2020	Ургамлын гарц сэргэн ургах боломж бүрдэнэ.		Аймаг, сумын ИТХ, Засаг дарга
5.10	Сумдад байгаль хамгаалах нөхөрлөлийг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх.	2017-2020	Байгаль хамгаалах 13 нөхөрлөл байгуулсан байна.	Орон нутгийн төсөв	Аймаг, сумын ЗДТГ БОАЖГ
5.11	Говь хээрийн болон цөлжилт ихээр явагдаж байгаа бүсэд ус хуримтлуулах, хиймэл нуур, хөв, цөөрөм байгуулах замаар экосистемийн тэнцвэрт байдал Дарьганга,Түмэнцогт сумдын Байгалийн дурсгалт болон байгалийн нөөц газрын баян бүрдийг хамгаалах,ойжуулах,нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг дэмжих.	2017-2020	Хөв цөөрөм байгуулснаар газрын доройтол багасна.	Улс, орон нутгийн төсвөөр	Бүх шатны Засаг дарга, БОАЖГ, Сав газрын захиргаад
5.12	Дарьганга,Түмэнцогт сумдын Байгалийн дурсгалт болон байгалийн нөөц газрын баян бүрдийг хамгаалах,ойжуулах,нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	2017-2020	Байгалийн аясаар ургаж буй ойн төгөл сэргэнэ.	Улс орон нутгийн төсвөөр	Аймаг, Сумын ЗДТГ БОАЖГ
5.13	Бэлчээр хамгаалах зохистой ашиглах, таримал бэлчээр бий болгох, хортон мэрэгчтэй тэмцэх, нөхөн сэргээхэд санаачилга гарган ажиллаж буй бэлчээр ашиглагч, малчдын бүлгийн ажилд дэмжлэг үзүүлэх.	2017-2020	Бэлчээрийн хортон мэрэгч багасна.	Улс орон нутгийн төсөв	Бүх сумдын ЗДТГ ХХААГ
5.14	Бүс нутгийн онцлог, бэлчээрийн даац багтаамжид тохируулан сүргийн оновчтой бүтцийг бий болгох арга хэмжээ авах.	2017-2020	Сүргийн оновчтой бүтэц бий болгох ажил хийгдэж эхэлсэн байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	Бүх шатны Засаг дарга ХХААГ,ТББ, малчдын бүлэг
5.15	Малчдын оролцоотойгоор бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.	2017-2020	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төлөвлөгөө боловсруулагдана. Энгийн уурхайн, гүн өрмийн худгууд гаргаж төлөвлөгөө болвсруулагдана.	Орон нутгийн төсөв	Бүх шатны Засаг дарга ХХААГ, МЭҮТ



5.16	Тариалангийн талбайн хөрсийг элэгдлээс хамгаалж хөрсний чанарыг бууруулахгүй байх зорилгоор ээлжлэн тариалалтыг зөв сэлгээтэй ашиглаж ойн зурвас байгуулж хөрсийг хамгаалах.	2017-2020	Тариалангийн талбайг зөв зохистой ашиглана.	Улс орон нутгийн төсөв	Аймаг, сумын Засаг дарга ХХААГ БОАЖГ
5.17	Аймгийн нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн хориглолт ба хязгаарлалтын бүсийг тогтоох	2017	Усны нөөц хомсдох, бохирдохоос хамгаалагдаж, үер, усны гамшгаас сэргийлэгдэнэ	Орон нутгийн төсөв	Аймаг, сумдын Засаг дарга, сав газрын захиргаад, БОАЖГ, холбогдох бусад байгууллагууд